

## ЗГХЭГ-ЫН ТӨРИЙН ЁСЛОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН

### ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН

2026.06.19

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Зорилго 5. Орчин үеийн шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ" холбогдох 5 зорилтын хүрээнд Төрийн ёслолын газраас 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилтын хүрээнд 18 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШҮДАГ-аас өгсөн үнэлгээ
1.	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын гадаад улсад хийх айлчлал, олон улсын арга хэмжээнд оролцох ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах (Зорилт 1)	1	5	97%	94%
2.	Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг хууль тогтоомж, журам, үндэсний ёс заншилд нийцүүлэн зохион байгуулах (Зорилт 2)	1	7	100%	91%
3.	Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарыг орон нутагт ажиллахад дагалдан явах, ёслол хүндэтгэлийн ажиллагааг зохион байгуулах (Зорилт 3)	1	3	100%	97%
4.	Монгол Улсын Ерөнхийлөгч нийтийн баяр, тэмдэглэлт өдрүүдээр цол, одон, медалиар шагнах ёслолын ажиллагааг зохион байгуулах (Зорилт 4)	1	1	100%	100%
5.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, айлчлал, уулзалтыг зохион байгуулах (Зорилт 5)	1	2	100%	83%
<b>Дундаж ерөнхий үнэлгээ</b>		<b>5</b>	<b>18</b>	<b>99%</b>	<b>92%</b>

ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ					
Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
ТӨГ	5	18	16	2	0

### ДҮГНЭЛТ

**Төрийн ёслолын газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 99 хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 92 хувиар үнэлэв**

Гүйцэтгэлийн тайлангаас зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт хагас жилийн хүрэх түвшинд бүрэн хүрээгүй, тайлагнал дутуу байсан тул үнэлгээг бууруулж тооцсон. Төрийн ёслолын газар нь 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хангалттай хэмжээнд хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **Төрийн ёслолын газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнд хүрсэн ажлаас дурдвал:**

- Монгол Улсын Ерөнхийлөгч БНКаЗУ-д төрийн айлчлал, УИХ-ын дарга БНХАУ-д айлчлахад бэлтгэл ажлыг хангаж, ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдад гадаадын зочин, төлөөлөгч бараалхах нийт 69 уулзалт, Итгэмжлэх жуух бичиг барих 20 ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг зохион байгуулсан.
- Цагаан сар, Үндсэн хуулийн өдөр, 3/8, Монгол цэргийн өдөр зэрэг 5 улсын нийтлэг баяр, тэмдэглэлт өдрийн төрийн ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгч 55 удаагийн цол, одон, медаль гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулсан.
- Нийт 1273 зөвшөөрлийг тухай бүр журмын дагуу олгон, мэдээллийн санг бүрдүүлсэн.

#### **Төрийн ёслолын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:**

- МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга тайлант хугацаанд гадаад айлчлал хийгээгүй бөгөөд 0 гүйцэтгэлтэй арга хэмжээг дараагийн хагас жилд эрчимжүүлэх шаардлагатай.

## ЗӨВЛӨМЖ

- Гадаад улсын зочин, төлөөлөгчдийн айлчлалыг дэмжих арга хэмжээг авч, тайлагналыг зорилтот шалгуур үзүүлэлттэй нарийн уялдуулан гаргах.
- Өдөр тутмын үйл ажиллагааны тоог суурь болон жилийн зорилттой харьцуулан явцын тайлагналд тусгаж, хоёрдугаар хагас жилийн ачааллыг тооцон эрчимжүүлэх.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ  
Б.ОРГИЛ

<b>ТӨРИЙН ЁСЛОЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН /ЗААЛТ БҮРЭЭР/</b>				
<b>Арга хэмжээний д/д</b>	<b>Арга хэмжээний дугаар</b>	<b>Өөрсдийн өгсөн үнэлгээ</b>	<b>ХШҮ хийсэн үнэлгээ</b>	<b>Үнэлгээний тайлбар</b>
<b>СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. ОРЧИН ҮЕИЙН ШААРДЛАГАД НИЙЦСЭН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ.</b>				
Зорилт 1. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын гадаад айлчлал, олон улсын арга хэмжээний ёслолыг зохион байгуулах				
1	1.1	100	100	МУ-ын Ерөнхийлөгч БНКаЗУ-д, УИХ-ын дарга БНХАУ-д айлчлахад урьдчилан явж бэлтгэл ажлыг хангасан. Хагас жилд 2 айлчлал — зорилт "тухай бүр, гүйцэтгэлээр".
2	1.2	100	100	Монгол Улсын Ерөнхийлөгч Казахстан-Астана бүс нутгийн уулзалт, УИХ-ын дарга Шатрын ОУ тэмцээн, Ерөнхий сайд Давосын Зуны чуулга — нийт 4 Олон улсын арга хэмжээний бэлтгэл ажлыг хангасан.
3	1.3	100	80	Хагас жилд нийт 1 гадаад зочин. БНСУ-ын Гадаад хэргийн сайд асан Пак Жин. Суурь 9, жилийн зорилт "тухай бүр" боловч хагас жилийн хугацаанд 1 хийгдсэн
4	1.4	100	95	Нийт 69 уулзалт — Ерөнхий сайд 32, УИХ-ын дарга 13, Ерөнхийлөгч 24. "Тухай бүр, гүйцэтгэлээр" тул хагас жилд 69.
5	1.5	100	95	Нийт 14 бэлэг. суурь 47, жилийн зорилт "тухай бүр". Хагас жилд 14 хийгдсэн нь 30%.
Зорилт 2. Төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах				
6	2.1	100	100	Цагаан сар, Үндсэн хуулийн өдөр, 3/8, Монгол цэргийн өдөр, Хүүхдийн эрхийн өдөр нийт 5 арга хэмжээний бэлтгэл ажлыг хангасан. Зорилт 5 → 5 → 100%.
7	2.2	100	90	Их Богд, Отгонтэнгэр уулыг тахих, Засгийн газрын гишүүн томиллолт/тангараг, тамга солилцоо нийт 3 бусад арга хэмжээ. Зорилт 4 → 3 → 1 дутуу.
8	2.3	100	90	Ерөнхийлөгчийн "Түмэн тэмээний баяр", Ерөнхий сайдын цэргийн дээд цолтнуудын арга хэмжээ, Генерал цолны 82 жилийн ой нийт 6 бэлтгэсэн. Суурь 65-аас 6 (9.2%)
9	2.4	100	85	1273 зөвшөөрөл суурь 2800-аас 45.5%. Уулзалт 582, туг 139, нисэх буудал 541, эмгэнэл 11. Хагас жилийн хэмжээнд хангалттай боловч суурь түвшингээс бага байна.
10	2.5	100	85	147 өдөр тутмын ёслол (Ерөнхийлөгч-36, УИХ-ын дарга-23, Ерөнхий сайд-45) суурь 339-ийн 43.4%.
11	2.6	100	90	1273 зөвшөөрөл хуулийн дагуу олгосон — суурь 1644-ийн 77.4%.

12	2.7	100	100	УИХ-ын дэд дарга, Шадар сайдын 2 үйл ажиллагаа, Шадар сайд ЭСЯ-тай золголт, ЗГХЭГ-ын дарга "Багануур"-г ажиллах. Зорилт "тухай бүр" → 100%.
<b>Зорилт 3. Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарыг орон нутагт ажиллахад дагалдан явах</b>				
13	3.1	100	90	15 орон нутгийн аймагт бэлэг, дурсгалын зүйл бэлтгэсэн — суурь 25, "тухай бүр". Хагас жилд 15.
14	3.2	100	100	ЕС 11 аймаг + 3 дүүрэг, УИХ-ын дарга 12 аймаг, Ерөнхий сайд 6 аймагт — нийт 30 орон нутгийн арга хэмжээ хийгдсэн. Суурь 25-аас давсан.
15	3.3	100	100	Шадар сайд Дархан-Уул, ЗГХЭГ-ын дарга 4 аймагт — нийт 5 арга хэмжээ зохион байгуулагдсан.
<b>Зорилт 4. Монгол Улсын Ерөнхийлөгч нийтийн баяр, тэмдэглэлт өдрүүдээр цол, одон, медалиар шагнах ёслолыг зохион байгуулах</b>				
16	4.1	100	100	55 удаагийн шагнал гардуулах ёслол — Ерөнхий сайдаас 55, УИХ-ын даргаас Үндсэн хуулийн өдөр, Цагаан сар, ЕС-аас 2 удаа. Зорилт "тухай бүр", суурь 32-аас 59 хийгдсэн.
<b>Зорилт 5. ЗГХЭГ-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, айлчлал, уулзалтыг зохион байгуулах</b>				
17	5.1	100	95	МУ-ын сайд, ЗГХЭГ-ын даргын гадаад зочинтой хийсэн 8 уулзалтын бэлтгэл ажлыг хангасан. Суурь 22, зорилт "тухай бүр" → хагас жилд 8.
18	5.2	100	70	МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга тайлант хугацаанд гадаад айлчлал хийгээгүй. Газраас 100% гэж тайлагнасан боловч 0 гүйцэтгэлтэй арга хэмжээг бүрэн биелсэн гэж тооцох үндэслэлгүй.
<b>Нийт дундаж үнэлгээ</b>		<b>99%</b>	<b>92%</b>	Дундаж үнэлгээ 7%-иар буурсан